



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2020 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 88

Мандалговь

Г

Б.Дэлгэрмандахыг албан тушаалд нэр  
дэвшүүлэх тухай

7

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2020 оны 5 дугаар хуралдааны шийдвэр, төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтын комиссын 2020 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Боловсрол соёл урлагийн газрын Биеийн тамир, дүрслэх урлаг, технологийн боловсрол хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Батчулууны Дэлгэрмандах 81.6 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр. Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Б.Дэлгэрмандахын санал, дүгнэлтийг хавсралтаар баталж, холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албандаа даалгасугай.


ДАРГА

Ц.ЭРДЭНЭСҮРЭН



190021048

Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь  
салбар зөвлөлийн 2020 оны ..... дугаар сарын  
15.. -ны өдрийн дүгээр тогтоолын хавсралт



**Боловсрол, соёл урлагийн газрын Биеийн тамир, дүрслэх урлаг, технологийн  
боловсрол хариуцсан мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлсэн  
Батчулууны Дэлгэрмандахын тухай дүгнэлт**

1. Б.Дэлгэрмандах нь 1987 онд Дундговь аймгийн Өндөршил сумын төвд төрсөн. 33 настай. Эмэгтэй.
2. Боловсролын байдал: Монгол улсын Боловсролын Их сургуулийг 2011-2015 онд боловсрол судлалын ухааны бакалавр зэрэгтэй суралцаж төгссөн. Технологийн багш мэргэжилтэй.
3. Ажлын туршлага: 2016 оноос хойш Адаацаг сумын Засаг даргын Тамгын газарт Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байгаа.
4. Б.Дэлгэрмандахын төрийн захиргааны албанад ажиллаж байгаа ажлын дадлага туршлага, тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Боловсрол, соёл урлагийн газрын Биеийн тамир, дүрслэх урлаг, технологийн боловсрол хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

**ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛ**